



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2025 оны 04 сарын 15 өдөр

Дугаар 82

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтад заасан 2 /хоёр/ хуулийн этгээдийн “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” тусгай зөвшөөрлийг тус тус 5 жилийн хугацаагаар сунгасугай.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тусгай зөвшөөрлийн хугацаа сунгагдсан хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

ГИШҮҮД



Г.ЧИНЗОРИГ

Б.АНХБААТАР


Б.БАТЗОРИГ

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР

Харилцаа холбооны зохицуулах хорооны
2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн
82 тоот тогтоолын
хавсралт



Тусгай зөвшөөрөл олгосон хуулийн этгээдийн
жагсаалт

№	Хуулийн этгээдийн нэр	Тусгай зөвшөөрлийн дугаар	Тусгай зөвшөөрлийн хугацаа	Хамрах хүрээ, Үйлчилгээний хүртээмж
1	Хаан Алтай ховд ХХК	23410022	2025.05.20 2030.05.20	Ховд аймгийн Жаргалант сумын нутаг дэвсгэрт Тоон телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээнд "Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах" Ашиглах давтамж: 550-590МГц
2	Дөрвөн шарга ХХК	23410005	2025.05.20 2030.05.20	Увс аймгийн Улаангом сумын нутаг дэвсгэрт Тоон телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээнд "Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах" Ашиглах давтамж: 550-590МГц

----- оОо -----